



**“МОН БИЙФ” ХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 40/᠑᠑3-12

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус анхдугаар
хурлыг зарлан хуралдуулах тухай.

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон Бийф” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, компанийн хэлбэр өөрчлөгдөж буйтай холбогдуулан “Мон Бийф” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус анхдугаар хурлыг 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторан “Гэр танхим”-д хуралдуулсугай.
2. Хурал зарлах мэдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлж олон нийтэд мэдээлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевизийн аль нэгээр дамжуулан 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн дотор, мэдээллийн давталтыг 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн дотор анх мэдээлсэн хэлбэрээр нэгээс доошгүй удаа мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурлын материалыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Хурлын даргаар Сүрэндулам овогтой Сайнбилэгтийг томилсугай.
7. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:
 - 7.1 Комиссын дарга:
 - 7.1.1 Хаан банкны ЭХДЗахирлын харьяа дата багийн менежер Эрдэнэбатын Нямцэнд;
 - 7.2 Комиссын гишүүд:
 - 7.2.1 Хаан банкны ЭХДЗахирлын харьяа дата багийн өгөгдлийн судлаач Алтанхүүгийн Ананд;
 - 7.2.2 Хаан банкны ЭХДЗахирлын харьяа дата багийн өгөгдлийн судлаач Алтангэрэлийн Амартүвшин.
8. Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хавсралт №1-ээр баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын загварыг Хавсралт №2-оор баталсугай.
10. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг Хавсралт №3-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт, уг баримт бичигтэй танилцаж болох газар, хугацааг Хавсралт №4-өөр баталсугай.
12. Хурлын дэгийг Хавсралт №5-аар баталсугай.

- 13 Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
- 14 Хурлыг холбогдох хууль, журмын дагуу зарлах болон зохион байгуулах ажлыг "Мон Бийф" ХК-ийн Гүйцэтгэх захирал /Н.Ариунбаатар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.БАТТУЯА